"МОНГОЛЫН ПАРАГЛАЙДИНГИЙН ХОЛБОО"
БАТЛАВ
ТЭРГҮҮН ..... А.БАТДАВАА

МОНГОЛЫН ПАРАГЛАЙДИНГИЙН ХОЛБООНЫ ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ ЭРХИЙГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилго нь Монголын Параглайдингийн Холбоо, (Цаашид МПХ гэх) гишүүн клубуудын зохион байгуулж буй тэмцээн, олон улсын тэмцээн уралдаанд оролцогчдын эрх, үүргийг тодорхойлж, шударга өрсөлдөөн, аюулгүй ажиллагаа, спортын ёс зүйн хэм хэмжээг хангах, Монгол Улсыг олон улсын тэмцээнд төлөөлөх үндэсний шигшээ багийн тамирчдыг сонгон шалгаруулах харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэхүү журам нь МПХ-ны дүрэм, холбогдох журам болон FAI/CIVL-ийн мөрдөгдөж буй дүрэмтэй нийцэж хэрэгжинэ.

ХОЁР. Хамрах хүрээ

2.1 Энэхүү журам нь МПХ-ны тэргүүн, Удирдах зөвлөлийн гишүүд, Мастер инструктор, Инструктор, Туслах инструктор, Холбооны гишүүн клубын нисгэгч, Бие даасан нисгэгч, Тэмцээнд оролцохоор бүртгүүлсэн бүх нисгэгчидэд адил үйлчилнэ.

ГУРАВ. Тэмцээнд оролцох эрх

3.1 Дараах шаардлагыг хангасан нисгэгч тэмцээнд оролцох эрхтэй байна:

3.1.1 МПХ-ны хүчин төгөлдөр гишүүн байх;
3.1.2 Хүчин төгөлдөр нисгэгчийн үнэмлэхтэй байх;
3.1.3 Тэмцээний бүртгэл, хураамжийг хугацаанд нь төлсөн байх;
3.1.4 Эрүүл мэндийн хувьд нислэг үйлдэх боломжтой байх;
3.1.5 Холбооны дүрэм, аюулгүй ажиллагааны журам, ёс зүйн дүрмийг хүлээн зөвшөөрсөн байх.

3.2 Монгол Улсыг төлөөлөн олон улсын FAI/CIVL тэмцээнд оролцох тамирчин нь энэхүү журмын 6 дугаар бүлэгт заасан шаардлагыг хангасан байна.

ДӨРӨВ. Тэмцээнд оролцох эрхийг түдгэлзүүлэх үндэслэл

4.1 Дараах тохиолдолд тэмцээнд оролцох эрхийг түр хугацаагаар эсхүл бүрэн хязгаарлаж болно:

4.1.1 Аюулгүй ажиллагааны ноцтой зөрчил гаргасан;
4.1.2 Стандарт шаардлага хангаагүй далавч хэрэгсэлтэй;
4.1.3 Спортын ёс зүйд харш үйлдэл гаргасан;
4.1.4 Шүүгч, зохион байгуулагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй;
4.1.5 Худал мэдээлэл, баримт бичиг бүрдүүлсэн;
4.1.6 Холбооны сахилгын шийтгэл хүчин төгөлдөр байгаа.

4.1.7 Тэмцээний үеэр болон тэмцээнтэй холбоотой үйл ажиллагааны үед согтууруулах ундаа хэрэглэсэн, согтууруулах ундааны нөлөөнд байсан; Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис хэрэглэсэн, хадгалсан, түгээсэн, эсхүл түүний нөлөөнд байсан; Аюулгүй нислэг үйлдэх чадварт сөргөөр нөлөөлөх эм, бодис хэрэглэсэн нь тогтоогдсон; Бусдын амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учруулахуйц үйлдэл гаргасан.

4.2 Согтууруулах ундаа, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн нь тогтоогдсон тамирчныг тухайн тэмцээнээс шууд хасах бөгөөд МПХ-ны сахилгын журмын дагуу нэмэлт сахилгын шийтгэл ногдуулж болно.

4.3 Энэхүү бүлэгт заасан зөрчлийг Тэмцээний зөвлөл, Ерөнхий шүүгч болон удирдах зөвлөл өөрсдийн эрх хэмжээний хүрээнд хэлэлцэн шийдвэрлэнэ.

ТАВ. Холбооны удирдлагын оролцоо:

5.1 Холбооны тэргүүн, Удирдах зөвлөлийн гишүүд тэмцээнд тамирчны хувиар оролцох эрхтэй.

5.2 Тэмцээнд оролцож байгаа удирдах албан тушаалтан нь тухайн тэмцээний шүүлт, үр дүн баталгаажуулалт, гомдол маргаан шийдвэрлэх ажиллагаанд оролцохгүй.

5.3 Ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд тухайн асуудлыг шийдвэрлэхэд оролцохоос татгалзана.

5.4 Холбооны удирдлага болон бүх тамирчин нь энэхүү журмын өмнө эрх, үүргийн хувьд адил тэгш байна.

ЗУРГАА. Олон улсын FAI/CIVL CAT 1 болон CAT 2 тэмцээнд оролцох эрх олгох, хадгалах

6.1 **CAT 1 тэмцээнд оролцох эрх:**

6.1.1 Олон улсын FAI/CIVL CAT 1 зэрэглэлийн тэмцээн, Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, Тивийн аварга шалгаруулах тэмцээн болон түүнтэй адилтгах тэмцээнд Монгол Улсыг төлөөлөн зөвхөн Монгол Улсын шигшээ багийн тамирчид оролцоно.

6.1.2 Монгол Улсын шигшээ багийн бүрэлдэхүүнийг МПХ, гишүүн клубуудын нэг жилд зохион байгуулсан болон баталгаажуулсан тэмцээнүүдийн нэгдсэн чансааны (ранкингийн) оноогоор тогтооно.

6.1.3 Шигшээ багийн чансааг Accuracy болон Cross Country (XC) төрлөөр тус тусад нь гаргана.

6.1.4 Шигшээ багт багтахын тулд өмнөх жилийн албан ёсны тэмцээнүүдэд оролцож чансааны оноо цуглуулсан байна.

6.1.5 Шигшээ багийн тамирчдын тоо нь FAI/CIVL болон тухайн тэмцээний зохион байгуулагч байгууллагаас тогтоосон квотын дагуу байна.

6.1.6 Шигшээ багийн бүрэлдэхүүнийг МПХ-ны Тэмцээний зөвлөлийн саналд үндэслэн удирдах зөвлөл баталгаажуулна.

6.1.7 Шигшээ багт багтсан тамирчин нь ёс зүй, сахилга бат, аюулгүй ажиллагааны шаардлага хангаагүй, эсхүл тэмцээнд оролцох боломжгүй болсон тохиолдолд дараагийн чансааны тамирчныг орлуулан оролцуулна.

6.2 **CAT 2 тэмцээнд оролцох эрх**

6.2.1 Монгол Улсыг төлөөлөн олон улсын FAI/CIVL бүртгэлтэй CAT 2 зэрэглэлийн Accuracy болон Cross Country (XC) тэмцээнд оролцох тамирчин нь МПХ-ны хүчин төгөлдөр гишүүн байна.

6.2.2 Олон улсын CAT 2 тэмцээнд оролцох эрх авахын тулд тухайн тамирчин нь хүсэлт гаргах өдрөөс өмнөх 24 сарын хугацаанд Монгол Улсад зохион байгуулагдсан МПХ, гишүүн клубын албан ёсоор баталгаажуулсан зургаа (6)-аас доошгүй тэмцээнд оролцсон байна.

6.2.3 МПХ-ны Тэмцээний зөвлөл нь тамирчны тэмцээний оролцоо, нислэгийн туршлага, аюулгүй ажиллагааны сахилга бат, спортын ёс зүйг үнэлэн CAT 2 тэмцээнд оролцох эрхийг баталгаажуулна.

6.2.4 Монгол Улсад тухайн төрөлд хангалттай тооны тэмцээн зохион байгуулагдаагүй болон бусад үндэслэл бүхий онцгой нөхцөл үүссэн тохиолдолд Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр энэхүү шаардлагаас чөлөөлж болно.

6.3 **CAT 2 тэмцээнд оролцох эрхийг хадгалах:**

6.3.1 Олон улсын CAT 2 тэмцээнд оролцох эрхтэй тамирчин нь эрхээ хадгалахын тулд жил бүр МПХ, гишүүн клубын албан ёсоор зохион байгуулж баталгаажуулсан хоёроос доошгүй тэмцээнд оролцсон байна.

6.3.2 Жил бүрийн шаардлагыг хангаагүй тохиолдолд тухайн тамирчны CAT 2 тэмцээнд оролцох эрхийг түдгэлзүүлнэ.

6.3.3 Түдгэлзүүлсэн эрхийг сэргээхийн тулд тамирчин нь МПХ-с албан ёсоор баталгаажуулсан хоёроос доошгүй тэмцээнд дахин оролцож, хүсэлт гаргана.

6.4 **Тэмцээний зөвлөл**

МПХ-ны Тэмцээний зөвлөл нь

6.4.1 Улсын чансаа (ранкинг)-г гаргах, баталгаажуулах;

6.4.2 CAT 1 болон CAT 2 тэмцээнд оролцох эрхийн шалгуур хангасан эсэхийг хянах;

6.4.3 Шигшээ багийн бүрэлдэхүүнийг санал болгох;

6.4.4 Тэмцээний үр дүн, бүртгэл, оролцооны мэдээллийг хөтлөх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

6.4.5 Тэмцээний зөвлөлийн бүрэлдэхүүнийг Удирдах зөвлөлийн хурлаар батална.

6.4.6 Тэмцээний зөвлөл нь үйл ажиллагаандаа шударга, ил тод, хараат бус байх зарчмыг баримтална.

ДОЛОО. Тамирчны үүрэг

7.1 Тамирчин нь

7.1.1 Аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг чанд мөрдөх;

7.1.2 Шүүгчийн шийдвэрийг хүндэтгэн биелүүлэх;

7.1.3 Бусад тамирчдын эрх ашгийг хүндэтгэх;

7.1.4 Спортын ёс зүйг сахих;

7.1.5 МПХ болон Монгол Улсын нэр хүндийг хамгаалах үүрэгтэй.

НАЙМ. Журам хүчин төгөлдөр болох

8.1 Энэхүү журмыг МПХ-ны удирдах зөвлөл баталж, батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөнө.

8.2 Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

Журам баталсан:

МПХ-ны удирдах зөвлөлийн гишүүд:

А.Батдаваа

Б.Болормаа

Н.Мөнхбаяр

П.Болд

С.Очхүү

Б.Дарамжав

П.Бэхболд

Г.Мөнхсайхан

Ц.Мягмардорж